

City of tomorrow.



- 01.** Toyota Showroom
- 02.** Encanto Centro-1 mixed-use residential building
- 03.** Stella Vista mixed-use residential building
- 04.** Encanto Trade Center
- 05.** Urt Tsagaan center
- 06.** Gerlug Vista residential town
- 07.** Vision Complex
- 08.** Love city master plan
- 09.** Toyota Service & Office Center

MGL E&C LLC


Барилга архитектур, инженерийн зураг төсөл чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, барилгын салбарт +10 жилийн туршлага, нөү-хаутай компани юм.

Орон сууцнаас эхлээд худалдаа, аж үйлдвэрийн цогцолбор хүртэлх 100 гаруй жижиг, том хэмжээний архитектурын төслийг амжилттай шийдэж чадсан. 2020 оноос хойш бид Улаанбаатар хотын өнгө үзэмжийг нэмсэн өндөр барилгуудын төслүүд дээр ажиллаж байна.

Бид барилгын иж бүрэн зураг төсөл боловсруулах, зохиогчийн хяналт болон төслийн менежментийн үйлчилгээ үзүүлдэг. Үүнд:

- Барилга архитектур
- Ландшафт
- Хот төлөвлөлт
- Барилга бүтээц
- Халаалт, агаар сэлгэлт
- Цахилгаан
- Ус хангамж, ариутгах татуурга
- Автоматик
- Холбоо дохиолол
- Интерьер дизайн
- Төслийн менежмент
- Зохиогчийн хяналт

Харилцагч байгууллагууд:



Барилга архитектурын алба

Барилга архитектурын ажлын зургийн баг

11 хүний бүрэлдэхүүнтэй, 3 ба түүнээс дээш жил ажилласан туршлагатай, мэргэшсэн архитекторуудаас бүрдэнэ. Голчлон ажлын зургийн үе шатанд ажиллаж, шугам сүлжээний инженерүүдтэй хоршин ажиллах, зургийг мэргэжлийн байгууллагуудаар хянуулах, батлуулах, зохиогчийн хяналт хийх зэрэг ажлуудыг хийдэг.

Барилга архитектурын концепцийн баг

13 хүний бүрэлдэхүүнтэй ба төслийн шинж чанартай багаа бүрдүүлж /adhocgasy/ хамтран ажилладаг соёлтой. Төслийн онцлогоос хамааран багийн аль ч гишүүн багийг ахалдаг ба ур чадвараас хамааран багаа бүрдүүлдэг. Судалгаа хийх, ажлын даалгаварт үндэслэн төлөвлөлтийн зарчим боловсруулна. Үүнээс 3 салж: 1. Судалгаа болон график, 2. 3D харагдах байдал болон ландшафт, 3. Ерөнхий төлөвлөлт болон барилгын төлөвлөлтийн зурж гүйцэтгэдэг.

Барилга бүтээцийн алба

Тус баг нь одоогийн байдлаар 10 инженерээс бүрдэх ба тэдгээрээс 4 нь мэргэшсэн зэрэгтэй. Барилга бүтээцийн баг нь мэргэжлийн болон программын ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхийн сацуу дотоодын болон гадаадын мэргэжил нэгтгүүдтэй туршлага солилцох үйл ажиллагаанд тогтмол хамрагдаж байна.

Инженерийн шугам сүлжээний алба

18 инженерийн бүрэлдэхүүнтэй. Халаалт агаар сэлгэлт, Ус хангамж ариутгах татуурга, Цахилгаан хангамж, Холбоо дохиолол, Автоматжуулалтын зургийг Revit программ дээр боловсруулдаг. Бид Монгол Улсад мөрдөгдөж буй норм дүрмийн дагуу, зургийн даалгаварт үндэслэн инженерийн зураг төслийн тооцоо, судалгаа, төлөвлөлт шийдэл, зохиогчийн хяналт зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэдэг.

Интерьер дизайны алба

6 хүний бүрэлдэхүүнтэй ба интерьерийн иж бүрэн зургийг боловсруулж байна. Ажлын зургийн үе шатандаа Revit программыг нэвтрүүлсэн.

Санхүү, менежментийн алба

Компанийн дотоод болон гадаад үйл ажиллагааг хариуцан зохион байгуулдаг бөгөөд Европын сэргээн босголт хөгжлийн банкны тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдаж “Хүний нөөцийн менежмент”-ийн үйлчилгээг нэвтрүүлэн ажиллаж байна.


ХАМТ ОЛОН

Функц ба гоо зүйн тэнцвэрт байдлыг хангасан загвар дизайн, нарийвчилсан, оновчтой инженерийн шийдэл, төслийн менежментийн арга барилыг хэрэгжүүлэхээр бид бүтээлч байдал, хамтын ажиллагааг тулгуураа болгон ажиллаж байна. Тулгарч буй сорилтуудыг даван туулах, төвөгтэй санааг ч амьдралд хэрэгжүүлэх, аливаа нөхцөл байдалд шинэ өнцгөөс хандах, илүү сайн шийдлийг бий болгохыг бид үргэлж эрмэлздэг.




Барилга архитектурын концепцийн баг


Санхүү, менежментийн алба




Интерьер дизайны алба





Барилга архитектурын ажлын зургийн баг



Барилга бүтээцийн алба




Инженерийн шугам сүлжээний алба



БИД ХЭРХЭН АЖИЛЛАДАГ ВЭ?

Одоогийн байдлаар бид **410 м²** оффисын талбайд үйл ажиллагаагаа явуулж байна.

Оффис дотор бүтэн цагаар нийт **60+** архитектор, инженерүүд ур чадвараа нэгтгэн, уялдаа холбоотой хамтран ажиллаж байна.



Барилга бүтээцийн алба

Батлагдсан загвар зургийн дагуу барилга бүтээцийн тооцоо хийгдэж эхэлнэ.

Тооцооны үр дүнгийн дагуу ажлын зургийн модель, арматурчлал хийгдэнэ.

Бэлэн болсон барилга бүтээцийн /ББ/ моделийг барилга архитектор /БА/ болон шугам сүлжээний инженерүүд рүү өгнө.

Ажлын зургийг хуудсанд бэлдэнэ.

Дууссан ажлын зургийг инженерийн багаараа хянаж шалгаж, магадлалаар оруулна.

Барилга архитектурын концепцийн баг

А даалгаврын дагуу суурь судалгаа хийж, дизайн боловсруулахад бэлтгэнэ.

Судалгаанд тулгуурлан 3 хувилбартайгаар гар эскизийг гүйцэтгэнэ.

Хувилбаруудыг төслийн ахлагчид хянуулан нарийвчлан танилцуулгад бэлтгэнэ.

Захиалагчид танилцуулан хувилбар сонгуулж, сонгогдсон хувилбарыг нарийвчлан БНБД-ийн дагуу концепци танилцуулгад бэлдэж батлуулна.

Батлагдсан хувилбарыг загвар зургийн стандартын дагуу бэлтгэн батлуулж, BIM моделийг ажлын зургийн багт хүлээлгэн өгнө.

Барилга архитектурын ажлын зургийн баг

Загвар зургийн төлөвлөлтийг дахин нягттална.

Барилга бүтээцийн инженертэй зөвшилдөн бүтээцийн шийдлийг гаргана.

Төлөвлөлт эцэслэгдсэний дараа шугам сүлжээний инженерүүдтэй инженерийн шийдэл гарган, ажлын даалгаврыг солилцож уялдаа холбоог хариуцаж ажиллана.

Захиалагчидтай ажлын явц болон шийдлүүдийн талаар уулзалт хийнэ.

2-3 хүний бүрэлдэхүүнтэй архитектурын баг шат дамжлагатайгаар ажлын зураглалыг гүйцэтгэнэ.

Санхүү, менежментийн алба

Захиалагч талтай төслийн уулзалт зохион байгуулж, төслийн дагуу зураг төсөл боловсруулах ажлын үнийн санал бэлтгэж хүргүүлнэ.

Төслийн гэрээг бэлтгэж, баталгаажуулна.

Компанийн хийж хэрэгжүүлж буй төслүүдийн ажлын явц болон захиалагч хоорондын уялдаа холбоог сайжруулах тал дээр РМ анхаарч шаардлагатай баримт бичиг, мэдээллийг цаг алдалгүй дамжуулж, хэрэгжилтэд хяналт тавина.

Гэрээний нөхцөлийн дагуу төслийн гүйцэтгэл, хугацаа болон санхүүжилт зэргийг хянаж, төслийн явцын тайлан мэдээллийг бэлтгэж захиалагч талд хүргүүлнэ.

Төсөл дуусах үед актаар хүлээлцэж, төслийг захиалагч талд хүлээлгэн өгнө.

Интерьер дизайны алба

Захиалагчтай уулзаж, интерьер дизайн боловсруулах ажлын даалгавар хүлээн авч, талбайн хэмжилт хийнэ.

Захиалагчийн хэрэгцээ шаардлагад үндэслэн, судалгааг хийж, үйл ажиллагааны онцлог хэв маягт тохируулан, төслийн дизайны шийдэл болон төлөвлөлтийн санааг боловсруулж захиалагчид хүргүүлж санал солилцоно.

Батлагдсан төлөвлөлт болон дизайны шийдэл дээр тулгуурлан 3D моделийг боловсруулан танилцуулж захиалагчаар батлуулна.

3D дизайны дагуу ажлын зургийг боловсруулна.

Бэлэн болсон зургийг захиалагчид хүлээлгэн өгнө.

Инженерийн шугам сүлжээний алба

Барилга архитектурын зургийг үндэслэн инженерийн шийдэл боловсруулж, төлөвлөлт хийгдэнэ.

Төлөвлөлтийн дагуу тооцоо, судалгаа хийгдэнэ.

Шугам сүлжээний инженерүүд ажлын даалгавар солилцоно.

Ажлын зургийг хуудсанд бэлдэнэ.

Дууссан ажлын зургийг шалгаж, магадлалаар оруулахад бэлдэнэ.

Энэхүү буландаа бид уншигчдадаа аль болох бодит байдлыг хүргэхийг зорин архитектур, инженер мэргэжлээр ажиллаж буй тэдний адал явдал, түүх, үзэл бодол, хуримтлуулсан туршлагын тухай нийтлэлийг бэлтгэлээ.

Мэргэжлээрээ 7 дахь жилдээ ажиллаж байгаа, Шинжлэх Ухаан Технологийн их сургуулийн Иргэний ба Үйлдвэрийн барилгын инженер /ИБУБ/ мэргэжлээр төгссөн MGL E&C компанийн **Барилга бүтээцийн инженер А.Батзориг**-той ажлын нэг өдөр нь хэрхэн өнгөрдөг болон ажиллах арга барилтай нь танилцаж, цомхон яриа өрнүүлээ.



ЯРИЛЦ – ЛАГА

Таны мэргэжил сонголтод юу нөлөөлсөн бэ?

Би ахлах ангиа Сүхбаатар аймгийн Нэгдүгээр 10-н жилийн сургуулийг төгссөн. Төгсөх хавар дөхөх тусам бусад хүүхдийн л адил ямар мэргэжлээр хаана суралцах талаар бодол болж, эцэст нь автайгаа зөвшилцсөний эцэст ШУТИС-д Иргэний ба Үйлдвэрийн барилгын инженер чиглэлээр элсэн суралцаж байв. Барилгын инженер чиглэлээр сурахад нэг талаас компьютер, технологи, төрөл бүрийн программ сонирхдог хобби маань их нөлөө үзүүлсэн. Их сургуулиа төгсөх жилийн хавар Зураг төслийн компанид дадлага хийх үед тухайн компаний ахлах маань инженер мэргэжлийг технологитой холбож, зураг төсөл боловсруулах, тооцооны үр дүнгээр бүтээцийн шийдэл хэрхэн гаргах зэргийг зааж зааварлаж чиглүүлсэн нь Бүтээцийн инженер мэргэжилдээ дурлаж цаашид энэхүү чиглэлээр ажиллах хүсэл эрмэлзлийг бий болгосон.

Их сургуулиа төгсөөд 2017 онд одоогийн компанидаа ажлын гараагаа эхэлж байв. Анх зөвлөх инженерийн удирдлага доор олон төрлийн бүтээцлэлтэй томоохон төслүүдийн ажлын зургийг хариуцан ажиллах боломж тохиосон. Эргээд бодоход анхны ажлаа зөв газарт, зөв хүмүүстэй эхлүүлэх нь ажлын арга барилаа олохоос эхлээд олон чадварт сургадаг юм билээ.

Таны ажлын дундаж нэг өдөр хэрхэн өнгөрдөг вэ?

Манай гэр ажлаас нэлээд зайтай байдаг болохоор өглөө эртлэн босож ажилдаа гардаг. Ажил дээрээ ирээд үдээс өмнөх сэргэг үеэ ашиглан тухайн өдрийн ажлаа төлөвлөж чухал дарааллаар нь эрэмбэлээд хийж эхэлдэг, үдээс хойш төвлөрөх ажлуудаа нугалж авна. Ер нь ажлаа өгөгдсөн цагт

багтаан **өндөр бүтээмж**тэй хийж дуусгаад, гэртээ эрт харьж, оройн цагийг аль болох хүүхдүүд, гэр бүлдээ зориулахад анхаардаг.

Хийх ажлаа хэрхэн төлөвлөдөг вэ?

Манай компани Барилгын зураг төслийн салбарт үйлчилгээ үзүүлдэг учраас Барилга архитектур, инженерийн шугам сүлжээний баг, захиалагч, төсөл гүйцэтгэгч талуудтай хамтран ажиллах шаардлага гардаг. Тиймдээ ч **7 хоног бүрийн эхэнд багаараа хуралдаад** хийгдэж байгаа төслүүдээ ярилцаад тухайн ажлыг хэзээ дуусах, ямар явцтай байгааг харах зэрэг олон үйлдлийг нэг дор хийдэг нь ажлаа төлөвлөхөд илүү амар байдаг.

Таны ажлын нөү-хау?

Ажлын арга барил дээр ч мэргэжлийн онцлог гарч ирнэ. Инженер хүний суурь зарчмын дагуу алдаа бага гаргах шаардлагатай учраас үргэлж нягт нямбай, хариуцлагатай байх шаардлагатай байдаг. Учир нь төсөл бүрийн ард их хэмжээний хөрөнгө оруулалт яригдаж байдаг тул **жижиг том ямар ч асуудлыг**

аль болох гүн рүү орж шийдэх нь чухал. Мөн аливаа асуудалтай тулгарвал **багаараа** ярилцаж богино хугацаанд инженерийн оновчтой шийдэл гаргахыг эрмэлздэг.

Мөн багийнхантайгаа ажлаа хийхэд нь саад болж байгаа зүйл бий эсэхийг ярилцдаг байх хэрэгтэй юм билээ. Угаасаа л багийн гишүүдийн бүтээмжээс ажлын үр дүн шууд хамаардаг шүү дээ.

Ашигладаг программуудаа дурдвал

Ажлын орчинд Autodesk-ын инженерийн программуудыг ашигладаг. Тэр дундаа Autodesk Revit бол манай байгууллагын гол хэрэглээ. Ажлыг үр дүнтэй, алдаа бага, хурдан хугацаанд явуулахад чухал үүрэг гүйцэтгэдэг ба архитектур болон бусад инженерийн багуудтай хамтарч төсөл хийхэд хялбар байдаг.

Ган бүтээцтэй барилгын хувьд **Tekla Structure** болон **IDEA Statica** ашиглаж тооцоо, ажлын зураг төсөл боловсруулдаг.

Залуу инженерүүдэд хандаж юу хэлэх вэ?

Тооцооны үндсэн суурь ойлголт, тооцоо хийх чадвар дээр нэмэгдээд ажлыг төлөвлөх, бүтээцийн шийдэл гаргах, бусадтай харилцан ойлголцох зэрэг суурь чадварууд чухал гэж харж байна. Эдгээр чадварууд дээр нэмэгдээд Гадаад хэлний чадварыг нэмж онцолмоор байна. Учир нь зураг төслийн инженерүүдийн ашигладаг программууд бүгд гадаад хэл дээр ба түүнийг нэг бүрчлэн заадаг, чиглүүлдэг сургалт хөвөр тул

инженер өөрийн хэлний мэдлэгийг ашиглан **бие даан суралцах** шаардлага үүсдэг.

Үүний зэрэгцээ аливаа зүйлийг өнгөц харж шийдвэр гаргалгүй, нухацтай бодож, харьцуулж үзсэнийхээ дараа эцсийн шийдийг гаргах хэрэгтэй. Гагцхүү тэгж гаргасан шийдвэртээ тууштай байх нь чухал шүү. Ялангуяа эхлүүлсэн ажлынхаа үр дүнг үзэх хатуужилтай байгаарай. Инженер хүнд олон зүйл хийж **алдаж, оносон турилгаа хамгийн чухал** шүү гэж хэлмээр байна.




- | | | | |
|--|--|--|---|
| 10. Imperia Holding apartment | 15. E-mart 5 commercial building | 20. Taigam Altai residential building | 26. BMW Showroom Mongolia |
| 11. 25-floors of mixed-use complex | 16. Admin office building | 21. MAK Galleria Zalaat | 27. Orkhon apartmen |
| 12. Mars V project | 17. Academy Service apartment | 22. Premium Bolor resort | 28. MAK Tsagaan Suvarga |
| 13. Encanto Orgil Palace | 18. Building material purchase center | 23. Jur Ur Factory building | 29. E-mart 4 commercial building |
| 14. Kaidu Mall - Cinema Next Entertainment center | 19. Admin of office building | 24. Altan Ord residential building | 30. MAK Darkhan |
| | | 25. Sky Park Plaza | 31. Encanto Orkhon apartment |

The Architecture Times



- 32.** Admin office building
- 33.** 25-floors of office building
- 34.** Land Mark office building
- 35.** Love City hotel & service building
- 36.** Nukht Naran Clubhouse



www.mglenc.com